



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 4/488

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Япон Улсын “Зүрх хамгаалах төсөл” ашгийн бус байгууллага хооронд 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 3 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081895

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 11. сарын 05-ны өдрийн
1/488 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Хигаки Такаши Higaki Takashi	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Япон Улсын “Зүрх хамгаалах төсөл” ашгийн бус байгууллага	ГЭ0002476	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	2019.11.01-2019.11.04 /4 хоног/
2.	Томита Хидэши Tomita Hideshi	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Япон Улсын “Зүрх хамгаалах төсөл” ашгийн бус байгууллага	ГЭ0002477	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	2019.11.01-2019.11.04 /4 хоног/
3.	Сүгияама Хисаши Sugiyama Hisashi	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Япон Улсын “Зүрх хамгаалах төсөл” ашгийн бус байгууллага	ГЭ0002478	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	2019.11.01-2019.11.04 /4 хоног/